



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Стандарт нэвтрүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.2.4, 11.1.1 дэх заалт, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны ажиллах журам”-ын 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ази-Номхон далайн бүсийн орнуудын итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага /Asia Pacific Accreditation Cooperation/-ын Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт нэгдсэн хүрээг “ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо” стандарт болон “ISO 37301 Нийцлийн менежментийн тогтолцоо” стандартын баталгаажуулалтын төрлөөр өргөтгөх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайдын ажлын алба (Б.Мөнх-Оргил), Үндэсний итгэмжлэлийн төв (С.Ням-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

2. “ISO/IEC 17021-9 Авлигын эсрэг менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалтын байгууллагын чадавхад тавих шаардлага”, “ISO/IEC 17021-13 Нийцлийн менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалтын байгууллагын чадавхад тавих шаардлага” стандартыг монгол хэлэнд орчуулж, үндэсний стандартаар баталж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайдын ажлын алба (Б.Мөнх-Оргил), Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар)-т тус тус даалгасугай.

3. “MNS ISO 37001 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, шаардлага ба хэрэглэх удирдамж” стандартын орчуулгыг хянан засварлаж, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудыг сургалтад хамруулахыг Монгол Улсын Шадар сайдын ажлын алба (Б.Мөнх-Оргил), Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар), Үндэсний итгэмжлэлийн төв (С.Ням-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгож, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т зөвлөсүгэй.

4. “ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо” стандартыг төрийн өмчит хуулийн этгээдэд үе шаттай нэвтрүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т үүрэг болгож, “MNS ISO 37001 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, шаардлага ба хэрэглэх удирдамж” стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Цемент шохой” ХХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Төрийн орон сууцны корпорац” ХХК, “МИАТ” ТӨХК, “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус зөвлөсүгэй.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Үндэсний хорооны орлогч дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН